

**ДААТГАЛЫН ЗУУЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД ЯАМДААС ИРҮҮЛСЭН
САНАЛУУДЫН НЭГТГЭЛ**

		Ирүүлсэн санал	Тусгасан байдал, тайлбар
1.	Батлан Хамгаалах Яамны санал	Хуулийн төслийн 30 дугаар зүйлийн 30.2-т “Хороо даатгалын ангилал, хэлбэр, төрлөөс хамааран даатгагчаас даатгалын зуучлагчид олгох борлуулалтын хөлс, орлогын шимтгэлийн хувь хэмжээ, хязгаарыг тогтоож болно.” гэсэн нь даатгагч, даатгалын зуучлагчийн хооронд иргэний эрх зүйн харилцааны хүрээнд үүссэн харилцаанд Хороо зуучлагчид олгох борлуулалтын хөлс, орлогын шимтгэлийн хувь хэмжээг тогтоох замаар оролцох нь зохимжгүй тул хуулийн төслөөс 30.2 дахь хэсгийг хасах;	Үгүй. 2024 оны 03 сард батлагдан гарсан Даатгалын зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл, баримтлалд “Даатгалын гэрээний зардлын багагүй (20-40) хувийг даатгалын төлөөлөгч, зуучлагчийн шимтгэлийн зардал эзэлж байдаг. Энэ хэмжээ сүүлийн жилүүдэд нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд энэ нь даатгалын хураамж нэмэгдэх, бүтээгдэхүүнээр бус шимтгэлийн орлогын хэмжээгээр өрсөлдөх гэх мэт сөрөг үр дагаврыг бий болгож байдаг учир Хороо зөвхөн шаардлагатай тохиолдолд даатгалын хураамжийн тооцооллын нэг хэсэг болох даатгалын гэрээний зардал буюу даатгалын зуучлагчид олгох борлуулалтын хөлс, орлогын шимтгэлийн хувь хэмжээ, хязгаарыг тооцоолох боломжийг байлгах үүднээс тус саналыг хүлээн авах боломжгүй.
2.		Хуулийн төсөлд төрийн оролцоог аль болох бага тусгах, хуулийн төсөл дэх Хороо (Санхүүгийн Зохицуулах Хороо)-той холбоотой зохицуулалтуудыг хууль санаачлагч цөөрүүлэх;	Хэсэгчлэн тусгав. 8.1, 8.2 заалтуудад цахимаар зөвшөөрөл олгохтой холбоотой болон бусад заалтуудад өөрчлөлт оруулав.
		Хуулийн төслийн 34, 35, 36, 37, 38, 39 дүгээр зүйлүүд дэх зохицуулалтууд нь Даатгалын тухай хуулийн 71, 72, 73, 74, 75, 76	Үгүй. Энэхүү хуулийн төсөл нь даатгалын бүтээгдэхүүн,

3.		дугаар зүйлүүдэд тусгагдсан зохицуулалтуудтай давхардаж байх тул хуулийн төслийн давхардлыг арилгах;	үйлчилгээг иргэд олон нийтэд зуучлан борлуулах тусгайлсан харилцааг зохицуулсан хууль тул хуулийн төслийн 2.3-т “Даатгалын зуучлалын үйл ажиллагаатай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулах бөгөөд энэ хуульд зохицуулснаас бусад харилцааг холбогдох хуулиар зохицуулна.” гэж заасны дагуу нарийвчилсан харилцааг энэхүү хуулиар зохицуулна.
4.	Эрчим Хүчний Яамны санал	Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэгт “Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулахдаа анхдагч хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хамтад нь боловсруулна.” гэж заасан. Иймд Даатгалын зуучлалын тухай болон Жолоочийн даатгалын хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулахдаа анхдагч хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хамтад нь боловсруулах нь зүйтэй байна.	Тийм. Саналыг тусгав.
5.		Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.5 дахь хэсгийг зөрчиж байх тул Даатгалын тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтын “аннуити”, 4.1.8 дахь заалтын “Даатгалын омбудсман”, 4.1.13а дахь заалтын “бенефишер”, 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсгийг “Сэндбоксын зохицуулалтын орчин”, 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсгийн “Компанийн засаглалын кодекс”, Даатгалын зуучлалын тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалтын “банкашурэнс” гэснийг тус тус монгол хэлний оноосон нэрээр бичих;	Хэсэгчлэн тусгав. “даатгалын омбудсман” нэр томъёог “даатгалын маргаан таслах зөвлөл” гэж тусгав. Хуульд тусгагдаагүй нэр томъёог захиргааны хэм хэмжээний актуудад ашиглахгүй учир уг хуулийн төсөлд тусгав.
6.	Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яамны санал	Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 17 дахь хэсэгт Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно гэж заасан тул “зөвшөөрөл авах хүсэлт гаргах, түүнд тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт” батлах тухай Даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1 дэх заалт, Даатгалын зуучлалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн	Үгүй. Бүрдүүлэх баримт бичиг нь Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэн хуулийн төсөлд оруулсан бөгөөд бүрдүүлэх баримт бичгийн маягт жагсаалт нь уг журмын төслөөр зохицуулагдана.

		6.2.1 дэх заалтыг тус тус хасах;	
7.		Зөвшөөрлийг хуульд тодорхой заан үндэслэл бүрдсэн тохиолдолд хүчингүй болгох шаардлагатай тул Даатгалын тухай хуулийн төслийн 80 дугаар зүйлийн 80.1.7 дахь заалт, Даатгалын зуучлалын тухай хуулийн төслийн 43 дугаар зүйлийн 43.1.7 дахь заалтыг тус тус заасныг хасах;	Үгүй. Компанийн тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль гэх мэт бусад хуулийн дагуу хүчингүй болгох үндэслэлүүд гарч болно.
8.		Хороо нь зөвхөн зөвшөөрөл авсан этгээдүүдийн хооронд гарсан маргааныг шийдвэрлэхээс гадна даатгагч, даатгуулагч, даатгалын зуучлал нарын хооронд үүссэн маргааныг урьдчилан шийдвэрлэх шаардлагатай тул Даатгалын тухай хуулийн төслийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт “Зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд даатгалын үйл ажиллагаатай холбогдон гарсан” гэсний дараа “даатгуулагч, даатгагчийн хооронд гарсан”, Даатгалын зуучлалын тухай хуулийн төслийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэгт “Зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд даатгалын үйл ажиллагаатай холбогдон гарсан” гэсний дараа “болон даатгагч, даатгалын зуучлал, даатгуулагч нарын хооронд гарсан” гэж тус тус нэмэх;	Хэсэгчлэн тусгав. Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 91-р зүйлд заасны дагуу даатгуулагч нь даатгагчид гомдол гаргах талаар, уг гомдлыг шийдвэрлэсэн шийдвэрийг эс зөвшөөрсөн тохиолдолд даатгалын омбудсманд гомдол гаргах эрхтэй талаар даатгагч нь даатгуулагчид мэдэгдэх үүрэгтэй гэж заасан. Харин даатгуулагчаас даатгалын зуучлагчид гомдол гаргах, маргааныг нь хэн шийдвэрлэх талаар хуулийн төсөлд тодруулж тусгав.
9.	Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам	Даатгалын зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагалдуулж Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийг хүчингүй болгох тухай хуулийн төслийг боловсруулах;	Тийм. Саналыг тусгав.
10.	Зам, Тээврийн хөгжлийн яам	Даатгалын тухай хуулийн төслийн 17 дугаар зүйлийн 17.5-д “Даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хугацаагүй олгох бөгөөд уг зөвшөөрөл нь энэ хуулийн 79, 80 дугаар зүйлд заасны дагуу түдгэлзүүлэх, хүчингүй болох хүртэл хүчин төгөлдөр байна.”, мөн Даатгалын зуучлалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-д “Энэ хуулийн 9.1 болон 10.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хугацаагүй олгох бөгөөд уг зөвшөөрөл нь энэ хуулийн 42, 43 дугаар зүйлд заасны дагуу түдгэлзүүлэх, хүчингүй	Үгүй. Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 3-д “Энэ зүйлийн 2-т зааснаас бусад зөвшөөрлийг хуульд заасан тохиолдолд хугацаагүй олгож болно.” гэж заасны дагуу уг хуульд хугацаагүй олгохоор заасан

		болгох хүртэл хүчин төгөлдөр байна.” гэж заасан нь Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 3-д “Энэ зүйлийн 2-т зааснаас бусад зөвшөөрлийг хуульд заасан тохиолдолд хугацаагүй олгож болно.” гэж заасантай нийцэхгүй байх тул тусгай зөвшөөрлийн хугацааг тодорхой заах;	учраас зөрчилдөөгүй байгаа болно.
11.	Цахим хөгжил, Харилцаа холбооны яам	Хуулийн төслийн 9.3-т “... ангиллыг дангаар нь, эсхүл хамтад нь эрхэлж болно” гэж заасан байгаа нь Даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэгт заасантай зөрчилдөж байх тул өөрчлөх;	Үгүй. Хороо даатгалын ангиллаар даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг давхардуулан олгохгүй байх тухай Даатгалын тухай хуулийн төсөл дэх заалт нь зөвхөн даатгалын үйл ажиллагаанд хамаарч байгаа бөгөөд даатгалын зуучлалын үйл ажиллагаанд хамаарахгүй болно.
12.		Хуулийн төслийн 11 дүгээр зүйлд заасан зөвшөөрөл хүсэх тухай зохицуулалтыг Даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэгт заасан “зөвшөөрөл хүсэх тухай өргөдлийг бичгээр болон цахим хэлбэрээр гаргах ...” зохицуулалттай нийцүүлж цахим хэлбэрээр өргөдөл, хүсэлт гаргах боломжийг хуулийн төсөлд тусгах;	Тийм. Саналыг тусгав.
13.		Хуулийн төслийн 27 дугаар зүйлд заасан улирал тутмын тайлангийн хугацааг “... дараа сарын 20-ны өдрийн дотор” гэсэн нь сар тутмын тайлан хүргэх хугацаа гэж ойлгогдож байх тул өөрчлөх;	Тийм. “... дараа сарын 20-ны өдрийн дотор ...” гэснийг “... дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор...” гэж өөрчлөв.
14.	Эдийн засгийн хөгжлийн яам	Төслийн 3.2.9-ийн “Санхүүгийн зохицуулах хороо” гэснийг “Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/” гэж өөрчлөх;	Тийм. Хуулийн төслийн 5.1-д тусгав.
15.		Төслийн 8.1-ийн “сэндбокс” гэснийг нэр томьёоны тайлбарт оруулах.	Тийм. Саналыг тусгав.
16.		Хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт “Хороо даатгалын зуучлалын үйл ажиллагааг хөгжүүлэх, боловсронгуй болгох, даатгал зуучлалын үйл ажиллагааг зохистой явуулах зорилгоор тусгайлан даатгал зуучлалын журмыг өөрийн бүрэн эрхийн хүрээнд баталж болно” гэж ерөнхий байдлаар тусгасныг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн захиргааны хэм хэмжээний актын зохицуулах харилцааг нэг бүрчлэн тодорхой тусгах.	Үгүй. Хуулийн төслийн 6.3 заалт нь зөвхөн хэм хэмжээний актыг батлах биш, дотооддоо дагаж мөрдөх дүрэм, журам, зааврыг батлахад хэрэглэнэ. Иймд хуулийн төсөлд тусгасан хэвээр байлгах нь зүйтэй гэж үзэв.

17.	Хууль зүй, Дотоод хэргийн яам	Хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт аливаа этгээд санхүүгийн үйлчилгээнд шинээр нэвтэрч буй технологид суурилсан шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнесийн загварыг Сэндбоксын зохицуулалтын орчинд туршсаны үндсэн дээр даатгалын зах зээлд нэвтрүүлэхээр заасан байна. Тус хэсэгт тодорхой программын нэр заасан нь цаашид бий болох өөр төрлийн хэрэгсэл хэрэглэх боломжийг хязгаарлах магадлалтай тул загварын нэрийг хасах.	Тийм. Нэр томьёоны тайлбар хэсэгт оруулав.
18.		Хуулийн төслийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт “Хороо даатгалын нөхөн төлбөр олгохтой холбогдсон харилцааг зохицуулсан журам баталж болно” гэж, 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт “Хороо даатгалын ангилал, хэлбэр, төрлөөс хамааран даатгагчаас даатгалын зуучлагчид олгох борлуулалтын хөлс, орлогын шимтгэлийн хувь хэмжээ, хязгаарыг тогтоож болно” гэж тус тус заасан нь хоёрдмол утгыг илэрхийлж байгаа буюу Хороо тус журмыг заавал батлахаар тусгаагүй байна. Хэрэв Хороо тус журмыг батлахгүй тохиолдолд хуулийн төсөлд дээрх асуудлын нарийвчилсан зохицуулалтыг тусгах шаардлагатайг анхаарах.	Үгүй. Хороо зөвхөн шаардлагатай тохиолдолд дээрх журмуудыг батлан гаргах учир тус саналыг хүлээн авах боломжгүй. Уг заалт дахь “тогтоож болно” гэдгийг “тогтооно” гэж найруулан өөрчлөв.
19.		Хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэгт даатгалын брокер хамтын даатгалын үйл ажиллагаанд оролцохтой холбоотой зохицуулалтыг журмаар нарийвчлан зохицуулахаар тусгасан байна. Гэтэл Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.18 дахь заалтад хамтын даатгалын үйл ажиллагаа нь даатгалын эрсдэлийг хэд хэдэн даатгагч хамтран даатгах даатгалын үйл ажиллагааны төрөлд хамаарах тул даатгалын брокер хамтын даатгалын үйл ажиллагаанд оролцохтой холбоотой нарийвчилсан зохицуулалтыг хуулийн төсөлд тусгах.	Үгүй. Уг харилцааг журмаар зохицуулах шаардлагагүй тул уг заалтыг хуулийн төслөөс хасав.
20.		Хуулийн төслийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд Хороо эрх олгох ба эрх олгох, олгохоос татгалзахтай холбоотой журмыг Хороо батална” гэж заасан нь Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 17 дахь хэсэгт “Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно” гэж заасантай зөрчилдөж байх тул зөвшөөрөлтэй холбогдох харилцааг хуулиар зохицуулах.	Тийм. Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэв.
		Хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.2 дахь заалтад заасан “тохиромжтой этгээдийг тодорхойлох шалгуур” гэж, 40 дүгээр	Үгүй. Хуулийн төслийн 6.2.6 заалтын дагуу тохиромжтой

21.		зүйлийн 40.1.6 дахь заалтад заасан “тохиромжтой бус этгээд” гэж тус тус тусгагдсан нь ойлгомжгүй байх тул тодорхой тусгах эсхүл хууль тогтоомжийн холбогдох заалтыг эшлэх.	этгээдийг тодорхойлох зааварт тодорхойлохоор зохицуулав.
22.		Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлээр өөрчлөн найруулах хэлбэрээр боловсруулсан нь хууль зүйн техникийн хувьд Хууль тогтоомжийн тухай хуульд заасантай нийцэхгүй байгааг анхаарах. Тухайлбал, “даатгалын мэргэжлийн оролцогч” гэснийг “даатгал зуучлагч” гэж өөрчилсөн байх тул хуульд өөрчлөлт оруулах хэлбэрээр боловсруулах нь зүйтэй.	Тийм. Саналыг тусгав.

---oOo---